



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 15 өдөр

Дугаар A/39

Өвт

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт  
хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тоогоол, Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2018 оны “Журам батлах тухай” А/274 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” А/55 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан хүнсний дэлгүүрүүдийн цагийн хуваарийг 20.00 цаг хүртэл ажиллуулах, суманд үйл ажиллагаа явуулж байгаа 4 эмийн санг хуваарийн дагуу 24 цагаар ажиллуулах, архи, согтууруулах ундааг 18.00 цагаас хойш худалдаалахгүй байх, караоке, баарны үйл ажиллагааг түр зогсоо арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг сумын штаб (Н.Бат-Эрдэнэ), Цагдаагийн хэсэг (З.Мягмарсүрэн) нарт үүрэг болгосугай.

3. Төрийн байгууллага, банк, худалдаа, үйлчилгээний газруудад амны хаалт зүүгээгүй иргэдэд үйлчлэхгүй байх, үйлчилсэн тохиолдолд нэн даруй зогсоо, төрийн болон хувийн хэвшлийн ариутгал, халдвартгуйжүүлэлтийг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллахыг сумын Эрүүл мэндийн төвийн дарга (О.Отгонболд), Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (П.Аюушжав), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Н.Түвшин) нарт үүрэг болгосугай.

4. Шашны байгууллагын шашин номын хурал, цуглаан, зан үйлд иргэд, олон нийтийг оролцуулахгүй байхыг Дэчинчойнхорлин хийд (С.Дүгэр)-д үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн төвд шаардлагатай байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдвартгуйжүүлэлтийн бодисын судалгааг тухай бүрд нь гаргаж, холбогдох байгууллагуудад болон сумын Онцгой комисст мэдээлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (О.Отгонболд)-д үүрэг болгосугай.

6. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай санхүүгийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг сумын Онцгой комисс(Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

№051010072

7. Цагаан сарын баярыг өргөнөөр тэмдэглэхгүй, хот, аймаг, сум дамжин золголт хийхгүй байхыг олон нийтэд өргөн хүрээнд таниулах сурталчлах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумын штаб (Н.Бат-Эрдэнэ), Соёлын төв байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумын штаб (Т.Жамъянжав, Д.Даваацэрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Л.Балжинням) нарт үүрэг болгосугай.

8. Хот хооронд болон орон нутгийн зорчигч тээврийн хэрэгсэлд ариутгал, халдвартгүйжүүлэлтийг хуваарийн дагуу хийх, асуумж бөглүүлэх, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (О.Отгонболд), Монгол засвар, Цэгээн хангайн зам ХХК-уудад үүрэг болгосугай.

9. Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх болон гудамж талбайн орчны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллахыг Багийн Засаг дарга (С.Төмөр, Л.Балжинням), байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

10. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэхтэй холбоотой шаардлагатай санхүүжилтийг тухай бүр шийдвэрлэхийг Санхүүгийн албаны дарга (Д.Бадамдулам)-д үүрэг болгосугай.

11. Онцгой байдлын өрөнхий газрын даргын 2018 оны A/274 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам”-ыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

12. Энэ ажлын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын мэдээ, тайланг тухай бүр аймгийн Онцгой байдлын газар болон Хархорин сумын Онцгой байдлын хэлтэст хүргүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

13. Сумын Засаг даргын “Томуу, томуу төст өвчний тархалтыг бууруулах, шинэ коронавирусний халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” 2020 оны A/24 дүгээр захирамжийг эрчимжүүлж ажиллахыг сумын штаб (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

14. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батчулуун)-д даалгасугай.

